

Written by hanoi
Wednesday, 20 June 2018 02:33 -

There are no translations available.



Вьетнамын Хочимин хотноо "Монгол амт- Монгол үндэсний хоолны долоон хоног" соёл, сурталчилгааны арга хэмжээг Монголын Блю Скай зочид буудал, Вьетнамын Виндсор Плаза зочид буудал хамтран 4 дүгээр сарын 20-29-ний өдрүүдэд амжилттай зохион байгуулж байна. Тус үйл ажиллагаанд Ханой дахь ЭСЯ, Вьетнамд суралцаж буй монгол оюутнууд дэмжлэг үзүүлж, соёл урлаг, мэдээлэл сурталчилгааны арга хэмжээг хамтатган зохион байгуулав.

Монголын үндэсний уламжлалт зоог, цагаан идээ, амттан, хоол хvнсийг Блю Скай зочид буудлын ахлах тогооч В.Дагвадорж, Т.Улсболд нар бэлтгэн сурталчилж, монгол оюутнууд уртын дуу, морин хуур, монгол бvжиг, монгол уран зураг, бийрэн бичлэгийн үзүүлбэрээ дэлгэн сонирхууллаа.

Вьетнамын ард тvмэнд Монгол Улс, нvүдэлчин ахуй, соёл урлагийг таниулан сурталчлах ажлыг санаачлан, онцгой дэмжлэг үзүүлсэн Блю Скай, Виндсор Плаза зочид буудлын захиргаа, Хочимин хотод суугаа Оргомжит консул Нгуен Суан Хань, Вьетнамд суралцагч монгол оюутнуудад Монгол Улсын ЭСЯ-ны зvгээс гvн талархал илэрхийлье!